



Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ

Авахад ямар материал бүрдүүлэх вэ?

Шинээр газар эзэмших, ашиглах тохиолдолд:

- Иргэний үнэмлэх (улсын бүртгэлийн гэрчилгээ)-ийн хуулбар
- Эзэмших, ашиглах газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харъяалал, байршил зааг хэмжээ зэргийг тусгасан нэгж талбарын тойм зураг
- Хамтран эзэмшигч, ашиглагчдын иргэнийн үнэмлэх(улсын бүртгэлийн гэрчилгээ)-ийн хуулбар
- Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагын тодорхойлолт

Газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгах тохиолдолд

- Иргэний үнэмлэх (улсын бүртгэлийн гэрчилгээ)-ийн хуулбар
- Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ эх хувиар
- Газар эзэмших, ашиглах гэрээ эх хувиар
- Кадастрын зураг эх хувиар
- Газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааны дүгнэлт эх хувиар
- Газрын төлбөр төлсөн тухай баримт

Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн олгох тохиолдолд:

- Иргэний үнэмлэх (улсын бүртгэлийн гэрчилгээ)-ийн хуулбар
- Газрын төлбөр төлсөн баримт
- Үрэгдүүлсний нотлох баримт
- Эрхийн гэрчилгээний үнэ төлсөн баримт

Газар эзэмших эрхийн гэрчилгээ барьцаалах, эзэмшил

газраа бусдад ашиглуулах тохиолдолд:

- Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ эх хувиар
- Талуудын иргэний үнэмлэх (улсын бүртгэлийн гэрчилгээ)-ийн хуулбар
- Газрын төлбөр төлсөн тухай баримт
- Хэрэв тухайн нэгж талбарын хамтран эзэмшдэг бол хамтран эзэмшигчийн зөвшөөрлийг нотариатаар гэрчилүүлсэн байна.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тохиолдолд:

- Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ эх хувиар
- Газар эзэмших, ашиглах гэрээ эх хувиар
- Кадастрын зураг эх хувиар
- Газрын төлбөр төлсөн баримт
- Талуудын иргэний үнэмлэх (улсын бүртгэлийн гэрчилгээ)-ийн хуулбар
- Газар эзэмших эрх шилжүүлэх тухай нотариатаар гэрчилүүлсэн гэрээ
- Хэрэв эзэмшиж буй газраа бусдад хэсэгчлэн шилжүүлж байгаа бол кадастрийн зургийн хуулбар дээр зай хэмжээг тавьсан тойм зураг

Үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар

- Газрын тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Байгаль орчны тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Байгаль орчин нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Архивын тухай хууль